



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/12

Сүхбаатар сум

Орон тооны бус дэд зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3. "н" Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 222 дугаар тогтоолын 11 дүгээр зүйлийн 11.1 заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд ашигт малтмалын үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусламж байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус дэд зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

-Аймгийн Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

-Аймгийн Татварын хэлтсийн дарга

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга

-Баянгол сумын Засаг дарга

-Хүдэр сумын Засаг дарга

-Мандал сумын Засаг дарга

-Орхонтуул сумын Засаг дарга

-Ерөө сумын Засаг дарга

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Байгаль орчны бодлого хариуцсан мэргэжилтэн

2. Олборлох үйлдвэрлэлийн тайланг жил бүрийн 04 дүгээр сарын 15-ны дотор Татварын ерөнхий газарт хүргүүлэн, иргэдэд нээлттэй мэдээлж, хяналт тавьж ажиллахыг дэд зөвлөлийн ахлагч, аймгийн Засаг даргын орлогч /Ж.Сайнцог/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ